



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 0/483

Арвайхээр сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, Спортын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсаа төлөөлөн Олимпын төрөлт таеквондогийн Ази болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин Э.Анар, Э.Ананд, Б.Алтантүлхүүр нарын тэмцээний зардалд тус бүр 1,000,000 (нэг сая) төгрөг, Өсвөрийн шатарчдын зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин Л.Долгормаа, Х.Хангай, дасгалжуулагч Г.Мөнхгал нарын зардалд тус бүр 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 6,000,000 (зургаан сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0952

D:My Doc. Zahiramj. Zasag darga